



**ӨМШӨГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТОЛОӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2021 оны 02 сарын 08 одор

Дугаар 21

Даланзадгад сум

"Говийн ирээдүй-Хүүхэд" хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 "ж", 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, Засгийн газрын 2019 оны 200 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 2/4 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн "Говийн ирээдүй-Хүүхэд" хөтөлберийг хавсралтаар баталсугай.
2. Хөтөлберийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган, хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаж, үр дүнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Р.Сэддорж/-д даалгасугай.
3. Боловсролын салбар, тэрийн болон тэрийн бус байгууллага, багш, эцэг эх, хүүхдүүдийн хамтын оролцоонд түшиглэн хөтөлберийг хэрэгжүүлж, үр дүнг нэгтгэн жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Р.Сэддорж/-д үүрэг болгосугай.



462210111

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 02 дугаар сарын 08-ны
едрийн 28 дугаар тогтоолын хавсралт

“ГОВИЙН ИРЭЭДҮЙ-ХҮҮХЭД” ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөрийн үндэслэл, шаардлага

Монголчуудын эх оронч үзэл өнө эртний уламжлалтай бөгөөд түүний түүхэн улбаа нь эртний нүүдэлчдийн газар нутгаа хайрлан хамгаалах сэтгэлгээнээс эхтэй. Монгол Улс уудам газар нутагтай, нүүдэлчдийн соёл иргэншилтэй, баялаг түүхтэй, хүүхэд, залуучуудад эх оронч ухаарал, үзэл, үндэсний бахархлыг төлөвшүүлэх асуудлыг хэт үндсээрхэг үзлийн үүднээс биш, тэдний өөрсдийгээ таних, төгөлдөржүүлэх, дангааршил хийгээд даяаршихуйд нийцэхүйц боловсрол, соёлын нэг чухал бүрэлдэхүүн хэсэг болгон дэвшүүлж байна.

Иймд хүүхэд, залуучуудад эх орноо хайрлан хамгаалах, хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулах үүргийг ухааруулан ойлгуулж, эх орон, тусгаар тогтол, эх хэл, говь нутгийн түүх, соёлоороо бахархах, дээдлэн хүндэтгэх, газар нутаг, байгаль орчноо хайрлах итгэл үнэмшигийг төрүүлэх замаар улс орныхоо тогтвортой хөгжлийг хангаж, тусгаар тогтолынхоо баталгааг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага урган гарч байна.

Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх нь Монгол Улсын язгуур эрх ашгийг бодлогын бүх түвшинд эн тэргүүнд тавих, монгол хүний хөгжил, эх оронч ухамсар, хандлага, монгол ахуй, өв соёл, зан заншлыг сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, чанарыг дээшлүүлэх суурь үндэс болно.

Шинээр боловсруулж байгаа “Говийн ирээдүй хүүхэд” хөтөлбөрийн зорилтуудыг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж буй хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдтэй хэрхэн уялдаж байгааг үзэхэд 2 үзэл баримтлал, 4 хууль, 3 бодлогын баримт бичиг, 3 үндэсний хөтөлбөртэй уялдсан байна.

Өмнөговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Өмнөговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 200 дугаар тогтоолоор батлагдсан “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр” нь энэ хөтөлбөрийг боловсруулах үндэслэл болж байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

2.1. Хүүхдийн монгол ёс заншлаа дээдэлсэн, эх оронч, үндэсний бахархлыг уламжлагч, эрх чөлөөт сэтгэлгээтэй, хөдөлмөрч, бүтээлч зөв хандлагыг төлөвшүүлж авьяас чадварыг хөгжүүлэн тогтвортой хөгжлийг хангахад энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

Гурав. Хөтөлбөрийн зорилт

3.1. Хөтөлбөрийн зорилгыг дараах зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ:

3.1.1. Хүүхдэд монгол ёс заншлаа дээдэлсэн, эх оронч үзэл төлөвшүүлэх;

3.1.2. Номоор дамжуулан хүүхдийг хөгжүүлж, төлөвшүүлэх, монгол үндэсний бичиг, эх хэл соёлын хэрэглээг нэмэгдүүлэх, өвлүүлэх;

3.1.3. Хүүхдийг эрх чөлөөт сэтгэлгээтэй, авьяаслаг, гадаад хэлний боловсролтой иргэн болгон төлөвшүүлж, хөгжүүлэх;

3.1.4. Хүүхэд, залуучуудад монголын нүүдэлчин ахуй амьдрал, мал аж ахуйн зан үйл, уламжлалыг таниулах, хөдөлмөрч, бүтээлч хандлагыг бий болгох;

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1. Хүүхдэд монгол ёс заншлаа дээдэлсэн, эх оронч үзэл төлөвшүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.1.1. Сургууль, цэцэрлэгт монгол ёс заншлын сургалтын орчинг бүрдүүлж, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдсан хичээлүүдэд ашиглаж байгаа сургалтын материал, хэрэглэгдэхүүн, гарын авлагад эх оронч үзэл. Монгол ахуй, өв соёл, зан заншлын агуулга, арга зүйг тусган хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

4.1.2. Сургууль, цэцэрлэг, гэр бүлийн орчинд ардын уламжлалт төрөл бүрийн тоглоом наадгайг бий болгож, хүүхэд багачуудад зааж сургах. тоглуулах, уралдаан, тэмцээн зохион байгуулах;

4.1.3. Говь нутгийн онцлог, түүхэн уламжлалд тулгуурлан эх оронч үзлийг хүүхэд. залуучуудад төлөвшүүлж, хөгжүүлэх, монгол ёс заншлыг өвлүүлэх зорилго бүхий өдөрлөг, "Өмнөговь аймгаа хэн сайн мэдэх вэ" уралдаан, арга хэмжээг зохион байгуулах;

4.1.4. Суралцагчдыг сэтгэл зүй, бие бялдрын өв тэгш хөгжилтэй болгох, цэрэг эх оронч үзэл төлөвшүүлэх арга хэмжээ зохион байгуулах;

4.1.5. Говь нутгийн үзэсгэлэнт байгаль, Монгол Улсын хил, түүхэн газар орноор хүүхэд. залуучуудыг тойрон ялгуулах хөдөлгөөн өрнүүлж, хэвшүүлэх, байгаль орчин, түүх, соёлын дурсгалын ач холбогдлыг ойлгуулж, хайрлах ухамсар, төлөвшгийг олгоход чиглүүлэх, тэднийг түүх, соёлын дурсгалыг арчлан хамгаалах үйл ажиллагаанд оролцуулах;

4.1.6. Хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх, соён гэгээрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд бүх шатны боловсролын байгууллагаас гадна төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, гэр бүл, эцэг эх, иргэдийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх;

4.1.7.Хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх хүрээнд тэмдэглэлт өдөр бүрийн онцлогт тохируулан өв соёл. уламжлалт ёс. зан үйл, ахуй, Монгол улсын болон Өмнөговь аймгийн түүхэн хүн, түүхэн үйл явдлыг сурталчлан таниулах;

4.1.8. Хүүхдэд ан амьтан, уул ус, ургамал ногоо, газар шороогоо хайрлах, хамгаалах, дээдлэх үзлийг төлөвшүүлж. нэн ховордсон амьтан ургамлыг судлах, таниулах арга хэмжээг зохион байгуулах;

4.2. Номоор дамжуулан хүүхдийг хөгжүүлж, төлөвшүүлэх, монгол үндэсний бичиг, хэл соёлыг зааж сургах, өвлүүлэх зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгкүүлнэ:

4.2.1. Төв номын сан болон сургуулийн номын сангийн сан хөмрөгийг баяжуулан өргөжүүлж, хүүхдийн номын сан, үлгэрийн өргөө, гэр номын санг бий болгож ая тухтай орчин бүрдүүлэх

4.2.2. Хүүхэд багачуудад зориулсан цахим ном, говь нутгийн онцлогийг харуулсан зурагт тайлбар толь, контентийг бий болгс;

4.2.3. Хүүхэд, залуучуудад монгол үндэсний бичгийг өргөн хүрээгээр зааж сургах, цэвэр сайхан бичдэг болгох зорилгоор "Эрдмийн хишиг" аяныг жил бүр зохион байгуулах;

4.2.4. Хүүхдийн заавал унших номын жагсаалтыг гаргаж, ном унших аян өрнүүлэх, эцэг эхчүүдтэй хамтран ажиллах;

4.3. Хүүхдийг эрх чөлөөт сэтгэлгээтэй, авьяаслаг, гадаад хэлний боловсролтой иргэн болгон төлөвшүүлж, хөгжүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.3.1. Хүүхдийн дунд ардын урлагийн төрөл болох үндэсний хөгжим, ардын аман билиг, уртын дуу, бүжгийг хөгжүүлэх, өвлүүлэх, түгээн дэлгэрүүлэх;

4.3.2. Хүүхдийн авьяасыг нээн хөгжүүлж, гар урлал, уран зураг, тэрэл зургийн галлерэйг байгуулах;

4.3.3. Хүүхдийн театрыг байгуулж, хөгжүүлэн, үйл ажиллагааг тогтолжуулах;

4.3.4. Хүүхдийн хөгжлийг хангасан урлаг, спортын дугуйлан, секцийн тоог нэмэгдүүлж, уралдаан, тэмцээн зохион байгуулах;

4.3.5. Хүүхэд залуучуудад техник сэтгэлгээ, зохион бүтээх чадварыг хөгжүүлэх, ирээдүйн инженер, зохион бүтээгчдийг бий болгох сургалт, уралдаан тэмцээн зохион байгуулах;

4.3.6. Хүүхэд, залуучуудын гадаад хэлний мэдлэгийг тасралтгүй дээшлүүлж, хэл сурхын орчинг бүрдүүлэх;

4.3.7. Монгол ёс заншил, эх оронч үзэл, ёс зүй, ухамсыг төлөвшүүлэх, байгаль орчноо хайрлан хамгаалах үйл ажиллагааг сурталчлан таниулах, хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх "Говийн ирээдүй" хүүхдийн нэвтрүүлэгтэй болох;

4.3.8. Соёлт урлагийн төрөлжсөн сургалттай сургуулийг өргөтгэх, хөгжүүлэх

4.4. Хүүхэд, залуучуудад Монголын нүүдэлчин ахуй амьдрал, мал аж ахуйн зан үйл, уламжлалыг таниулах, хөдөлмөрч, бүтээлч хандлагыг бий болгох зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.4.1. Хүүхдийг хөдөлмөрт сургах "Хөдөлмөр зуслан"-ийн тоог нэмэгдүүлэн ажиллуулж, "Буюнт хотхон" хүүхдийн зусландаа амьдрах арга ухааны зуны сургалтыг зохион байгуулах;

4.4.2. Хаврын улиралд Төлчин хүүхэд, зуны улиралд Ногоочин хүүхэд, намрын улиралд Хадланч хүүхэд, өвлийн улиралд Өлчир хүүхэд арга хэмжээг зохион байгуулах;

4.4.3. Хүүхдийг амьдрах арга ухаанд сургах урлан бүтээх төвилг байгуулан, "Шавь сургалт"-ыг зохион байгуулах;

4.4.4. Бага насны хүүхдийг хөдөлмөрт сургах туршилт, танин мэдэхүйн төвийг сургууль, цэцэрлэгт бий болгох;

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

5.1. Хөтөлбөрийг 2021-2024 онд 1 үе шаттай хэрэгжүүлнэ:

Зургаа. Хөтөлбөрийн үр дүн

6.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

6.1.1. хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлж, монгол ёс заншиас суралцах орчин бүрдэнэ;

6.1.2. эх орон, тусгаар тогтолцоороо бахархах, хайрлан хамгаалах, хөгжүүлэх үйл хэрэгт хүүхэд, залуучуудын оролцос нэмэгдэж тэдний сюун санаа, ухамсарт эзрэг хандлага төлөвшиж, бие бялдрын хөгжил сайжирна;

6.1.3. хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвэшүүлэхэд бүх шатны байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа харилцан уялдаж, хүүхдийн ном, контентын тоо нэмэгдэнэ.

6.1.4. Хүүхдийг мал аж ахуйтай танилцуулж, хедөлмөрч, бүтээлч хүүхдийг бий болгоно.

Долоо. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

7.1. Хөтөлбөрийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

№	Зорилт	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин	Мэдээллийн эх сурвалж
1	Хүүхэд монгол ёс заншиас дээдэлсэн, эх оронч үзэл төлөвшүүлэх	Монгольн уламжлалт тоглоом наадгайд суралцсан хүүхэд, нийт хүүхдэд эзлэх жин	Тоо, хувь	3000	12000	
		Монгол ёс заншилын сургалтын орчинг бүрдүүлсэн сургууль, цэцэрлэгийн эзлэх жин	Хувь	20	70	Боловсрол, соёлын статистик мэдээ, Боловсрол, соёл урлагийн газар, сургууль, цэцэрлэгийн жилийн эцсийн тайлан, мэдээлэл
		Хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх, монгол ёс заншилыг өвүүлэхээр зохион байгуулсан	Toо	6	24	
				5000	20000	

		уралдаан тэмцэн, өдөрлөг, үйл ажиллагааны хэмжээ, хамрагдсан <u>хүүхэд</u>					
		Номоор дамжуулан хүүхдийг хөгжүүлж, төлөвшүүлэх, монгол үндэсний бичиг, эх хэл соёлын хэрэглээг нэмэгдүүлэх, евлүүлэх	Ном уншсан хүүхэд, хүүхдийн уншсан ном	Тоо	2538 20185	10000 80740	
2		Хүүхэд зориулан гаргасан ном, контент		Тоо	3	8	Соёлын статистик мэдээ
		Хөтөлбөрийн хүрээнд шинээр зохион байгуулсан секц дугуйлангийн хэмжээ, түүнд хамрагдсан хүүхдийн эзлэх жин	Тоо, хувь	9 525	20 2100		Боловсрол, соёлын статистик мэдээ.
		Хүүхэд залуучуудын тадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэхээр зохион байгуулсан		3	12		Боловсрол, соёл урлагийн газар. сургууль, цэцэрлэгийн жилийн эцсийн
		арга хэмжээ, түүнд хамрагдсан <u>хүүхэд</u>	тоо	753	3000		тайлан, мэдээлэл
3	Хүүхдийг эрх чөлөөт сэтгэлгээтэй, авьяаслаг, гадаад хэлний боловсролтой иргэн болгон төлөвшүүлж, хөгжүүлэх	Хүүхэд залуучуудын техник сэтгэлгээ, зохион бүтээх	Тоо				
		чадварыг хөгжүүлэх		2	8		
		чиглэлээрх үйл ажиллагааны хэмжээ, хамрагдсан <u>хүүхэд</u>		190	760		

		Мал ахуйтай танилцсан хөдөлмөрт суралцсан хүүхэд	аж	Тоо	80	1400	
		Хүүхэд, залуучуудад монголын нүүдэлчин ахий амьдрал, мал аж ахуйн зан үйл, уламжлалыг таниулах, хөдөлмөрч, бүтээлч хандлагыг бий болгох	Хүүхэдийн дунд зохион байгуулсан шавь сургалт, түүнд хамрагдсан хүүхэд, хийсэн бүтээлийн хэмжээ	Тоо	9 төрөл, 230 хүүхэд, 541 ширхэг бүтээл	12 төрөл, 1000 хүүхэд, 2000 бүтээл	Боловсролын статистик мэдээ, Боловсрол, соёл урлагийн газар, сургууль, цэцэрлэгийн жилийн эцсийн тайлан, мэдээлэл
4			Бага насны хүүхдийг хөдөлмөрт сургахаар шинээр байгуулсан туршилт, танин мэдэхийн төв	Тоо	3	12	
				тоо	1	4	

Найм. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэр

8.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараахь эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

- 8.1.1. улсын болон орон нутгийн төсөв;
- 8.1.2. төсөл хөтөлбөр, хандив тусламж;
- 8.1.3. бусад эх үүсвэр.

Ес. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээ

9.1. Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг тухайн оны 12 дугаар сард багтаан Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэст хүргүүлна.

9.2. Хөтөлбөрийн хэрэгжилтэд Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээг хийх бөгөөд Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг 1 жил тутамд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төргүүлэгчдийн хуралд танилцуулна. Мен хагас жил тутамд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нийгмийн бодлого, Хууль эрх зүйн хороонд танилцуулна.

9.3. Шаардлагатай тохиолдолд хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш 18 сараас доошгүй хугацааны дараа үр дүнд суурилсан явцын болон хөндлөнгийн үнэлгээ хийлгэж болно.